

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ОНЦЛОХ АЖЛЫН МЭДЭЭ

2022.03.11

Хараат

Ерөнхий боловсролын сургуультай хамтран “ЕБС,СӨБ-ын нийт эцэг эхчүүдэд зориулж “ХҮҮХЭД ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭЕРЭГ АРГА” сургалтыг зохион байгууллаа. Сургалтад цэцэрлэгийн 2 бүлэг, сургуулийн эцэг, эхчүүд нийт 47 иргэд хамрагдлаа. Сургалтыг Хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтын сургагч багш нар явууллаа.



Гурвансайхан суманд зохион байгуулагдсан тэмцээний бага насны Мини волейболын төрөлд Г.Энхсайхан дасгалжуулагчтай Э.Эрдэнэ-Очир, Э.Ган-Эрдэнэ, М.Тэмүжин нар алтан медаль, Э.Эрдэнэ-Очир "ӨСӨХ ИРЭЭДҮЙТЭЙ ТАМИРЧИН"-аар шалгарсан амжилтыг тус тус үзүүлээ.



Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Илүүдэл жингүй – Эртэч монгол” аяны дагуу өглөө бүр спорт зааланд дасгал хөдөлгөөн хийж байна.



Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Жавхлант бүсгүй-2022” уралдааныг амжилттай зохион байгууллаа. Уралдаанд нийт 7 бүсгүй оролцож авхаалж, самбаа ур ухаанаа сорин өрсөлдлөө. Нэгдүгээр байранд Хараат багаас оролцогч Д.Намуунбайгаль, хоёрдугаар байранд Замын-Улаан багаас оролцогч М.Эрдэнэжаргал, гутгаар байранд Төрийн банкнаас төлөөлөн оролцсон Б.Цэндсүрэн, тусгай байранд Хүүхдийн цэцэрлэгийн оролцогч Т.Насан-Эрдэнэ нар шалгарлаа.



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР